



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ  
ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

# ШҮҮХЭД ИТГЭХ ИРГЭДИЙН ИТГЭЛ

САНАЛ АСУУЛГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН



## АГУУЛГА

УДИРТГАЛ .....	2
1. ШҮҮХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ.....	4
2. ШҮҮХ ӨӨРЧЛӨГДСӨН ЭСЭХ, ШҮҮХИЙН ӨӨРЧЛӨЛТ .....	9
3. ШҮҮХЭД ИТГЭХ ИРГЭДИЙН ИТГЭЛ, ТЭГШ БАЙДАЛ.....	11
4. ШҮҮГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, ШҮҮГЧИЙН ТАЛААРХ ИРГЭДИЙН ТӨСӨӨЛӨЛ .....	16
5. ШҮҮХИЙН ШИНЭТГЭЛД ЦААШИД ТУЛГАРЧ БҮЙ СОРИЛТ .....	17
ДҮГНЭЛТ.....	22
ХАВСРАЛТ (Шүүхэд итгэх итгэл).....	24



## УДИРТГАЛ

2013 онд шинэчлэн байгуулагдсан Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхийн үйлчилгээг ил тод нээлттэй, хүртээмжтэй болгох, олон нийтийн хяналтыг тогтоох нөхцөлийг бүрдүүлэх, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх байдалд онцгой анхаарч ирсэн. Энэ хүрээнд 2014 онд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс “Шүүх ба олон нийт” хөтөлбөрийг баталж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Мөн 2017 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” сэдэвт олон нийтийн санал асуулга явуулах тухай тушаал баталсан бөгөөд уг судалгааг жилд 2-оос доошгүй удаа авах, ингэхдээ нөхцөл байдлыг бодитой үнэлэх үүднээс шүүхээр үйлчлүүлсэн иргэд болон шүүхээр үйлчлүүлж байгаагүй иргэдийн хүрээнд явуулж байх юм.

### (1) Судалгааны зорилго, хамрах хүрээ

Шүүх ба олон нийтийн харилцааг бэхжүүлэх, эргэх холбоо тогтоох, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, шүүхийн ил тод нээлттэй байдлыг хангах, шүүхийн үйлчилгээнд олон нийтийн хяналтыг бий болгоход энэ судалгааны зорилго оршино.

Дээрх зорилгод үндэслэн олон нийтийн санаа бодлыг дараах байдлаар томъёолж, мэдээлэл цуглуулав. Үүнд:

- Шүүхийн үйлчилгээ, хүндрэл, бэрхшээл;
- Шүүх өөрчлөгдсөн эсэх, шүүхийн өөрчлөлт;
- Шүүхэд итгэх иргэдийн итгэл, шударга байдал;
- Шүүгчийн сонгон шалгаруулалт, шүүгчийн талаарх иргэдийн төсөөлөл;
- Шүүхийн шинэтгэлд цаашид тулгарч буй сорилт;

### (2) Судалгааны мэдээлэл цуглуулсан арга

Судалгааны мэдээллийг Монгол Улсын нийт шүүхийн хэмжээнд социологийн судалгааны санал асуулгын аргыг ашиглан гүйцэтгэв.


**Анкетын судалгаа:** Олон нийтийн үнэлэмжийг бодитой тогтоож, цаашид үйл ажиллагааны чиглэлийг тогтоож, шүүхийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх арга замыг тодорхойлоход асуулгын судалгааны аргыг ашигласан бөгөөд нийгмийн судалгааны бусад аргуудыг хавсарсан байдлаар ашиглаагүй болно.

*Жич: Анкет 2 төрөл байх бөгөөд шүүхээр үйлчлүүлж байсан болон байгаагүй иргэд гэсэн хоёр төрөлтэй болно.*

### (3) Судалгааны түүвэр, байршил

Судалгаанд шүүхээр үйлчлүүлсэн 1523, шүүхээр үйлчлүүлээгүй 1523 нийт 3046 иргэн оролцсон байна. /Дэлгэрэнгүй задаргааг хавсралтаас үзнэ үү/.

### Судалгаанд оролцогчдын насны бүлэг (Шүүхээр үйлчлүүлээгүй иргэд n=1523)



“Шүүхэд итгэх иргэдийн итгэл” санал асуулгын судалгааг шүүхээр үйлчлүүлсэн болон шүүхээр үйлчлүүлээгүй нийт 3046 иргэнээс авсан. Шүүхээр үйлчлүүлээгүй 1523 иргэн хамрагдсанаас 32.9 хувь нь 18-30 настай, 28.7 хувь нь 31-40 настай, 22.1 хувь нь 41-50 настай, 4.9 хувь нь 61 ба түүнээс дээш настай хүмүүс хамрагдсан байна.

**Мэдээллийн нууцлалыг хангах:** Санал асуулгыг авахдаа иргэд олон нийтээс бусдын нөлөөлөлд автахгүй байх, өөрийн үзэл бодлоо нээлттэй, шударгаар илэрхийлэх боломжоор хангаж ажилласан.

#### (4) Судалгааны мэдээлэл цуглуулах, боловсруулах ажиллагаа

Судалгааны мэдээллийг шүүхийн тамгын газруудаас Шүүхийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс хүлээн авч, битүүмжлэлийг задалж, санал асуулгын анкетыг тоолж, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн мэдээллийн санд шивж оруулан, үр дүнг нийгмийн судалгааны SPSS 20.0 программыг ашиглан бодож гаргав.

## 1. ШҮҮХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ


### Шүүхээр үйлчлүүлээгүй иргэд

**График 1.1. Таны танил шүүхээр үйлчлүүлсэн эсэх**



Судалгаанд хамрагдсан шүүхээр үйлчлүүлээгүй иргэдийн 51.1 хувьд тэдний хэн нэгэн танил болон ойр тойрны хүмүүс шүүхээр үйлчлүүлсэн байна.

**График 1.2. Хэрэв иргэд шүүхэд ямар нэг асуудлаар хандвал**



Хэрэв шүүхэд ямар нэг асуудлаар хандвал иргэдийн 52.1 хувь (36.9+15.2) буюу талаас илүү хувь нь шүүх өөрчлөгдсөн гэж сонссон тул санаа нэг их зовохгүй бөгөөд шүүх, шүүгчид асуудлаа хуулийн дагуу зөв ойлгуулахыг хичээнэ гэж хариулснаас үзвэл шүүхээр огт үйлчлүүлээгүй иргэдийн хувьд шүүх асуудлыг нь шударга, тал харалгүй, хуулийн дагуу шийднэ гэдэгт итгэх хувь өндөр байгааг харуулж байна. Мөн үүнийг 2013 оноос эрчимтэй хэрэгжиж буй шүүхийн шинэтгэл, түүний үр дүнг нийгэм хэрхэн хүлээж авч буйн илрэл гэж болохоор байна.

Харин иргэдийн 18.7 хувь (11.9+6.8) нь шүүхэд ямар нэг асуудлаар хандвал санаа зовно, танил талаараа дамжуулж ярина, хөөрөө хийлгэнэ гэж хариулснаас харахад иргэдийн бага хэсэг нь шүүхийн бие даасан байдлын талаарх ойлголт дутмаг бөгөөд шүүх тал хардаг төрийн захиргааны байгууллага гэсэн хуучинсаг хэвшмэл ойлголт байсаар байна. Энэ нь Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн бие даасан байдал, шүүхийн шинэтгэлийн талаар олон нийтийг мэдээллээр хангах ажлаа эрчимтэй хэвээр үргэлжүүлэх, үр дүнг тооцож ажиллах шаардлага байсаар байгааг харуулж байна.

Үлдсэн 29.2 хувь буюу 1/3 нь яах талаар хэлж мэдэхгүй байна гэжээ. Энэ нь иргэд эрхээ хамгаалуулах тал дээр тодорхой ухамсартай бодолгүй, идэвхгүй байдалтай байгааг нөгөө талаас иргэдийн эрх зүйн мэдлэг дутмаг байгааг харуулж байна. Иймд Засгийн газрын зүгээс хууль сурталчлах үйл ажиллагаагаа сайжруулах шаардлагатай байна.


### Шүүхээр үйлчлүүлсэн иргэд

**График 1.3. Хэдэн удаа шүүхээр үйлчлүүлж байна вэ?**




“Шүүхэд итгэх иргэдийн итгэл” санал асуулгын судалгааг шүүхээр үйлчлүүлсэн болон шүүхээр үйлчлүүлээгүй нийт 3046 иргэнээс санал авсан. Шүүхээр үйлчлүүлсэн 1523 иргэн хамрагдсанаас 35 хувь нь өмнө нь 1 удаа үйлчлүүлж байсан, 37.2 хувь нь өмнө нь олон удаа үйлчлүүлж байсан, 27.8 хувь нь анх удаагаа шүүхэд хандсан иргэд байна. Үүнээс харахад дийлэнх нь буюу 72.2 хувь нь шүүхийн үйлчилгээг 2 ба түүнээс дээш удаа авсан иргэд байна.

**График 1.4. Шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхэд ямар нэг хүндрэл гарсан уу?**



Шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлж, үйлчилгээ авахад иргэдийн  $\frac{3}{4}$  нь ямар нэг хүндрэл, бэрхшээл гараагүй гэснээс харахад шүүхийн үйлчилгээ ноцтой дутагдалгүй, ерөнхийдөө хэвийн түвшинд явагдаж байна гэж үзэхээр байна. Үүнийг 2013 оноос эхлэн хэрэгжиж байгаа Шүүхийн тухай багц хуулиудын хүрээнд шүүхийн эрх зүйн орчин сайжирч, шинэтгэл амжилттай хэрэгжиж байгаа, хэрэг маргааны төрлөөр шүүхийг дагнуулан байгуулж, шүүгч мэргэшин ажиллаж байгаа, хэргийн ачаалалтай уялдуулан шүүгчдийн орон тоог нэмэгдүүлсэн, шүүгчдийн бүрэлдэхүүнийг шинэ шүүгчдээр сэлбэсэн, шүүхийг үйлчилгээний байгууллага болгох талаар авч хэрэгжүүлсэн ажлын үр дүн гэж үзэж болно. Үүнийг орон нутаг болон нийслэлийн шүүхээр харьцуулж харвал дараах байдалтай байна.

**График 1.5. Шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхэд хүндрэл гарсан эсэх**



Нийслэл дэх шүүхүүдээр үйлчлүүлсэн иргэдийн 36.5 хувь, орон нутагт байрлах шүүхүүдээр үйлчлүүлсэн иргэдийн 18.1 хувь нь “шүүхээр үйлчлүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарсан” гэж

хариулжээ. Нийслэл, орон нутгийн судалгааны үр дүн ялгаатай байгаа бөгөөд “хүндрэл тулгарсан” гэж хариулсан хүний тоо нийслэлд 2 дахин өндөр байна.

2013 оноос эхлэн хэрэгжүүлсэн шүүхийн шинэчлэлийн хүрээнд нийслэл, орон нутаг дахь шүүхийн хэргийн ачааллыг тэнцвэржүүлэх үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлснээр 2017 оны хагас жилийн байдлаар эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хувьд хэргийн ачаалал дүүргийн шүүхийн нэг шүүгчид 30.1 хэрэг, орон нутгийн шүүхийн нэг шүүгчид 24.3 хэрэг, иргэний хэргийн шүүхийн хувьд дүүргийн шүүхийн нэг шүүгчид 162.4 хэрэг, орон нутгийн шүүхийн нэг шүүгчид 131.2 хэрэг, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хэргийн ачаалал улсын дундаж 14 хэрэг бөгөөд нийслэл дэх захиргааны хэргийн шүүхийн нэг шүүгчид 27.7 хэрэг, орон нутагт байрлах дийлэнх шүүхийн хувьд 1 шүүгчид 10 хүрэхгүй хэрэг тус тус ногдож байгаа юм<sup>1</sup>. Захиргааны хэргийн шүүхийн хувьд нийслэлд 2 дахин, эрүү болон иргэний хэргийн шүүхийн хувьд нийслэлд тус бүр 20 орчим хувиар өндөр ачаалалтай байгаа нь судалгааны үр дүнд нөлөөлсөн гол хүчин зүйл байж болох талтай. Түүнчлэн төвлөрсөн хот, суурин газар болохын хувьд нийслэл дэх шүүхүүдийн шийдвэрлэж буй хэргүүд илүү ээдрээ, төвөгтэй байхыг үгүйсгэхгүй. Цаашид нийслэл дэх шүүхүүдээр үйлчлүүлсэн иргэдийн хувьд тулгарсан нийтлэг бэрхшээлийг нарийвчлан судалж, илрүүлэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Судалгаанд оролцогчдын дөрөвний нэг буюу 25 хувь нь шүүхээр үйлчлүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарсан гэж хариулсан нь нийт шүүхүүдийн үйлчилгээнд дутагдалтай тал, сайжруулах зүйлүүд байгааг харуулж байна. Тулгарсан хүндрэл, бэрхшээлийг дараах байдлаар томъёолсон байна. Үүнд:

**График 1.6. Ямар бэрхшээл тулгарсан эсэх**



Шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхэд гарч буй нийтлэг хүндрэлүүдийг авч үзвэл тэдгээр нь шүүгчийн ур чадвар, харилцаа хандлага болон шүүхийн тамгын газрын үйлчилгээтэй аль алинтай нь холбогдож байна.

Шүүгчдийн тухайд судалгаанд оролцогчдын 27.6 хувь нь хэргийн оролцогчдод шударга, тэгш хандаагүй, 16 хувь нь харилцаа хандлага таалагдаагүй зэрэг нь хүндрэлтэй байсан гэж хариулжээ. Энэ нь хэдийгээр шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн субьектив үнэлэлтээс хамаарсан дүн боловч шүүгч нь Монгол Улсын хууль тогтоомж, Шүүгчийн ёс зүйн дүрэмд заасны дагуу ёс зүйн өндөр хэм хэмжээг сахиж, шударга ажиллахаас гадна тийнхүү харагдахуйцаар үйлдэл,

<sup>1</sup> Монгол Улсын шүүхийн 2017 оны хагас жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ

харилцаагаа авч явах үүргээ хэрэгжүүлэхэд цаашид тодорхой хэмжээнд анхаарах шаардлагатайг харуулж байна.

Судалгаанд оролцогчдын 32.5 хувь нь шүүгчийн мэдлэг, чадварт эргэлздэг гэж хариулсан нь анхаарал их татаж байна. Иргэд шүүгчийн өндөр ёс зүй, мэргэжлийн ур чадвар, мэдлэгт итгэх түвшин нь шүүхийн нэр хүнд, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг тодорхойлох нөлөөтэй. Шүүхийн шинэтгэлтийн хүрээнд шүүгчийн орон тоог 60 гаруй хувиар нэмэгдүүлж, нилээдгүй шинэ шүүгчдээр шүүх бүрэлдэхүүнийг сэлбэсэн боловч шүүгчийн мэдлэг, чадварт эргэлзсэн иргэд байсаар байгаа нь Монгол улсад шүүхийн хүний нөөцийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх шаардлага байсаар байгааг харуулж байна.

Мөн шүүгчдийн мэдлэг, чадварын суурь нөхцөл нь Монгол Улсын эрх зүйн боловсролын тогтолцоотой шууд хамааралтай. Өнөөгийн тогтолцоогоор дээд боловсрол эзэмшсэн эрх зүйч 2 жил шүүх, хуулийн салбарт дадлага хийж, 3-аас доошгүй жил мэргэжлээрээ ажиллан хангалттай мэдлэг, туршлага хуримтлуулж чадалгүй шууд шүүгч болох боломжтой зэрэг нь дэлхийн нийтлэг жишигтэй нийцэхгүй байгаа. Тухайлбал гадаадын улсуудад хууль зүйн дээд боловсрол дүүргэсний дараа эрх зүйчид law school зэрэг мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоогоор боловсрогдож, ажлын туршлагатай болсны дараа шүүгч болох мэдлэг, ур чадвараа олж авдаг. Иймд цаашид Монгол Улс шүүгч буюу дээд зэргийн мэргэшсэн хуульчид ажиллах энэ албан тушаалд ажиллах хүний нөөцийн мэдлэг, чадварыг дээшлүүлэхийн тулд мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоотой болох зайлшгүй шаардлагатай гэдгийг тус судалгаа харуулж байна.

Дээрхээс үзэхэд шүүхэд итгэх иргэдийн итгэлийг дээшлүүлэхийн тулд шүүгч бэлтгэх хууль зүйн боловсролын тогтолцоо, тэр дундаа мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоотой болох, чанартай боловсрол эзэмшсэн, шүүгчийн зан чанар, ёс зүйн шаардлагад нийцэхүйц шинэ нөөцөөр шүүхийн хүний нөөцийг шинэчлэх ажлыг гүнзгийрүүлэх шаардлага байна гэж дүгнэж байна.

Шүүхийн шийдвэрийг цаг хугацаанд нь гардуулаагүй нь иргэдийн шүүхэд итгэх итгэлийг бууруулах бас нэг хүчин зүйл болж байна. Шүүхийн шийдвэрийг хуулийн хугацаанд албажуулахгүй байгаад хэд хэдэн хүчин зүйл нөлөөлдөг. Нэг талаас шүүхийн ачаалал зарим шүүхүүдэд хэт өндөр байгаа тул шүүгчид ачааллаа даахгүй нөхцөл байдал үүсдэг. Улсын Их Хурлын 2016 оны 42 дугаар тогтоолоор анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн орон тоог 693 байхаар тогтоосон боловч өдгөө 500 орчим шүүгч ажиллаж байна. Төсвийн хүндрэлтэй холбоотойгоор батлагдсан орон тоогоор шүүгчдийг ажиллуулахгүй байгаа энэ үеэд хууль тогтоох байгууллага анхаарч ачааллыг тэнцвэржүүлэн шүүгчийн тоог нэмэгдүүлэн ажиллуулах нь шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлэх юм.


Нөгөө талаас шүүгчид хуулийн хугацаанд шийдвэрийг албажуулахдаа хайнга хандах, мөн шүүгчдийн ур чадвар дутмаг байдлаас болж ажлын хурд, бүтээмж дутагдалтай байгаа нь иргэдийн шүүхэд итгэх итгэлийг сулруулахад нөлөөлж байна гэж үзэж болохоор байна. Иймд өмнө дурдсанчлан шүүгчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, шүүхийн хүний нөөцийг шинэтгэх ажилтай шүүхийн ажлын бүтээмжийн үр дүн харилцан уялдаатай юм.

Дараагийн хэсэгт, шүүхийн үйлчилгээ муу, хүнд сурталтай байсан, шүүхийн захиргааны ажилтны харилцаа хандлага тааруу байсан гэж 5 хүн тутмын 1 нь үзсэн нь Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхийн захиргааны ажилтны хариуцлагыг дээшлүүлэх, үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй болгох чиглэлээр онцгой анхаарч эрчимтэй ажиллах шаардлагатайг харуулж байна.



Судалгаанд хамрагдсан 5 хүн тутмын 1 нь шүүхийн байр, дэд бүтэц муу байгаа нь шүүхэд итгэх иргэдийн итгэлийг бууруулж байна гэж үзсэн нь шүүхийн хөрөнгө оруулалтын төсвийг сүүлийн жилүүдэд “0” төгрөгөөр баталсан, зориулалтын шүүхийн барилга байгууламж Монгол Улсад хөгжөөгүй байгаатай холбоотой бөгөөд үүнд Монгол Улсын Засгийн газар, хууль тогтоох байгууллага анхаарах цаг болсныг судалгааны дүн харуулж байна.

**График 1.7. Ямар бэрхшээл тулгарсан эсэх /Нийслэл, орон нутаг/**




Шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхэд гарч буй нийтлэг хүндрэлүүдийг орон нутаг болон нийслэлд байрлах шүүхүүдээр харьцуулж үзвэл дийлэнх асуудлууд нь нийслэлийн шүүхүүдэд төвлөрсөн байгааг харж болно. Нийслэлд байрлах шүүхийн хувьд “шийдвэрийг цаг хугацаанд нь гардуулаагүй” гэсэн хариулт судалгаанд оролцогчдын 35.3 хувь буюу орон нутаг дахь шүүхүүдээс даруй 2 дахин их, мөн шүүхийн байр, дэд бүтэц муу гэсэн хариултыг 31.4 хувь буюу орон нутаг дахь шүүхийн үзүүлэлтээс даруй 3 дахин өндөр байгаа нь анхаарал татаж байна. Энэ нь нийслэлд байрлах шүүхүүдийн ажлын ачаалал өндөр, шүүхээр үйлчлүүлэгсдийн тоо их байгаатай холбоотой бөгөөд ажлын ачаалал, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, нийслэл дэх шүүхийн дэд бүтцийг сайжруулах зайлшгүй шаардлага, хэрэгцээ байгааг иргэдээс авсан судалгааны үр дүн илтгэж байна. Судалгаанд оролцогчдын 21 хувь нь орон нутгийн шүүхүүдэд “Шүүхийн үйлчилгээ муу, хүнд сурталтай байсан” гэж хариулсан нь орон нутаг дахь шүүхийн үйлчилгээг иргэдэд илүү ойртуулах, түргэн шуурхай, чирэгдэлгүй болгоход онцгой анхаарах шаардлагатайг харуулж байна.

Харилцан ашиг сонирхлын зөрчилтэй талуудын маргаан, гомдлыг эцэслэн шийдвэрлэж байдаг тул шүүгчийн шийдвэр туйлын утгаараа талуудад таалагдах, эс таалагдах харьцаа 50:50 хувьтай байх хэдий ч “Нийслэлд байрлах шүүхийн шүүгчдийн мэдлэг, чадварт эргэлзсэн” гэсэн хариултыг судалгаанд оролцогчдын 40.4 хувь нь сонгосон байгаа нь харьцангуй өндөр тоо. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нийт шийдвэрийн 25 орчим хувьд, иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн 9 орчим хувьд, Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн 85 орчим хувьд нь тус тус давж заалдах шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэдэг. Иймд шүүхийн шийдвэр, түүний үндэслэлийн хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлыг сайжруулах

асуудалд шүүгч нар онцгой анхаарах, Шүүхийн захиргааны байгууллагын зүгээс шүүгч бэлтгэх хөтөлбөрийг улам чанаржуулах, шүүгчдийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхэд сургалтын үйл ажиллагааг бүрэн чиглүүлэх шаардлагатай байна.

## 2. ШҮҮХ ӨӨРЧЛӨГДСӨН ЭСЭХ, ШҮҮХИЙН ӨӨРЧЛӨЛТ

**График 2.1. Шүүхээр үйлчлүүлэхэд ямар сэтгэгдэл төрсөн бэ?**




Шүүхийн шинэтгэл хэрэгжиж эхэлснээс хойшхи шүүхийг өмнөх байдалтай нь харьцуулж шүүхээр үйлчлүүлж байсан иргэдээс шүүх өөрчлөгдсөн буюу шүүхийн шударга байдал, үйлчилгээ сайжирсан эсэхийг асуухад иргэдийн тал хувь нь буюу 47.4 хувьд шүүх шинэчлэгдэн сайжирч байгааг мэдэрсэн гэсэн хариулт өгснөөс үзвэл шүүхийн шинэтгэл бодитой үр дүнд хүрснийг иргэдийн тал хувь нь шууд хүлээн зөвшөөрч байна гэж үзэж болохоор байна.

Харин үлдсэн 52.6 хувь нь шүүх өөрчлөгдсөн гэдгийг хэлж мэдэхгүй байна, өөрчлөлт мэдрээгүй гэж хариулснаас харахад иргэдийн зарим хэсэгт шүүхийн шинэтгэлийн хэрэгцээ шаардлага, үйл явц, үр дүн, шударга шүүхийн зүгээс иргэдийн амьдрал үзүүлэх ач холбогдлын талаар бодит мэдээлэл, сурталчилгааг хангалттай хүргээгүй байна гэж үзэхээр байна. Иймд олон нийтийг шүүхийн мэдээллээр хангах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай нь харагдаж байна.

Шүүхийн өөрчлөлтийн талаар орон нутаг болон нийслэлээр харьцуулж үзвэл төдийлөн ялгаатай өөрчлөлт харагдахгүй байгаа нь шүүхийн шинэтгэлийн бодлого нийслэл орон нутагт ялгамжгүй, тэгш явагдаж байгааг харуулж байна.

**График 2.2. Шүүхээр үйлчлүүлэхэд ямар сэтгэгдэл төрсөн бэ? /Нийслэл, орон нутаг/**



**График 2.3. Шүүх яаж өөрчлөгдсөн бэ?**




Шүүхийн шинэтгэлийн 11 гол үр дүнгээс иргэд алийг нь илүү их мэдэрсэн, тэдний амьдралд ач холбогдолтой гэж үзэж байгааг асуухад шинэтгэл ерөнхийдөө мэдрэгдэж байна, эвлэрүүлэн зуучлал үр дүнтэй хэрэгжиж байгаа, шүүхийн үйлчилгээ өмнөхөөсөө мэдэгдэхүйц сайжирсан гэдэгтэй иргэд хамгийн их санал нийлжээ. Тухайлбал, шүүх дэх эвлэрүүлэн зуучлал 2014 оноос манай улсад хэрэгжиж шүүхэд ирж буй иргэдийн 5 нэхэмжлэл өргөдөл тутмын 1-ийг эвлэрлийн журмаар шийдвэрлэж байгаа нь шүүхийн ачааллыг 20 хувиар бууруулж байгаа эерэг үзүүлэлт юм. Ингэснээр эвлэрүүлэн зуучлал нь шуурхай явагдаж, цаг хугацаа, мөнгийг хэмнэж, нийгэмд энх тайванч уур амьсгалыг авчирснаар иргэдийн амьдрал, аж ахуйн үйл ажиллагаанд хамгийн түрүүнд бодитоор тусч буй шүүхийн шинэтгэлийн үр дүн болсоныг энэ судалгааны үр дүн мөн харуулж байна.

Түүнчлэн шүүхийн үйлчилгээнд цахим инноваци нэвтэрсэн, шүүхийн шийдвэр нээлттэй, үйл ажиллагаа нь ил тод болсон гэдэгтэй иргэдийн олонхи санал нийлжээ. Энэ нь шинэтгэлийн хүрээнд [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) сайтад шүүхийн шийдвэрийг нээлттэй тавьдаг болсон, шүүх хуралдааны бичлэгийг нөхөж үзэх, иргэдийн шүүхийн байранд очиж үйлчлүүлэх орчин нөхцлийг нээлттэй болгосон зэрэг нь иргэдийн шүүхэд итгэл итгэл нэмэгдэхэд нөлөөлжээ.

Харин шүүх бие даасан захиргаатай болсон, шүүхийн хараат бус байдал дээшилсэн, хүний нөөц шинэчлэгдэж байгаа, шүүх дагнаж, шүүгч мэргэшсэн зэрэг шинэтгэлийн өөрчлөлтүүд иргэдэд туссан түвшин доогуур байна. Энэ нь шүүхийн шинэтгэлийн дээрх чиглэлүүд нь шүүхийн өөрийн тогтолцоо, байгууллагын дотоод ажил, хүчин зүйлтэй холбоотой буюу иргэдийн амьдралд шууд хамааралгүй чиглэлүүд тул иргэд тухайлан ач холбогдол өгөхгүй байгаатай холбоотой байж болох юм. Гэвч эдгээр чухал өөрчлөлтийг иргэдэд мэдрүүлэх, ойлгуулах ажлыг нэмэгдүүлэх шаардлага байгааг илтгэнэ.

### 3. ШҮҮХЭД ИТГЭХ ИРГЭДИЙН ИТГЭЛ, ТЭГШ БАЙДАЛ


**График 3.1. Шүүх хэрэг, маргааныг шударгаар шийдвэрлэнэ гэдэгт хэр итгэж байна вэ?**



Шүүхээр үйлчлүүлсэн иргэдээс **шүүх хэрэг, маргааныг шударгаар шийдвэрлэнэ гэдэгт хэр итгэж байна вэ?** гэж асуухад 63.1 хувь нь шүүхдээ итгэнэ гэж шууд хариулжээ. Шүүхийн шинэтгэл хэрэгжиж эхлэхээс өмнө буюу 2007 оны судалгаагаар шүүхэд итгэх иргэдийн итгэл 30 хувиас бага байдаг байсан бол энэ удаагийн судалгаагаар 63.1 хувь нь шүүхэд итгэдэг гэж үзсэн нь шүүхийн шинэтгэлийн үр дүнд шүүхэд итгэх иргэдийн итгэл дээшилснийг харуулж байна. Энэ нь шүүхийн шинэтгэлийн үр дүнг хэмжих хамгийн гол үзүүлэлт мөн. Шүүхэд итгэх иргэдийн итгэл нь тогтмол хөдөлгөөнгүй үзүүлэлт биш тул цаашид иргэдийн итгэлийг тасралтгүй нэмэгдүүлэх, үзүүлэлтийг бууруулахгүй байх тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй юм.

Шүүхэд итгэдэггүй гэж хариулсан иргэдийн хувь маш бага буюу 3.5 хувь байна.

**График 3.2. Шүүхэд итгэх олон нийтийн итгэл /Нийслэл, орон нутаг/**




Шүүхэд итгэх олон нийтийн итгэлийн байдлыг орон нутаг болон нийслэлд байрлах шүүхээр харьцуулж харвал нийслэлд 60 орчим хувь, орон нутагт 70 орчим хувь нь шүүхэд итгэдэг гэж хариулсан нь 2000-аад оны эхэн үеийн судалгааны дүнтэй харьцуулахад харьцангуй өндөр өсөлттэй үзүүлэлт юм. Үүнийг 2013 оноос хэрэгжүүлж буй шүүхийн шинэчлэлийн эерэг үр дүн гэж харж байна. Гэсэн хэдий ч шүүхэд итгэх итгэл өөрөө маш эмзэг бөгөөд иргэдийн итгэлийг бууруулахгүй байх, тогтмол өсгөхөд байнга анхаарч ажиллах шаардлагатай. Түүнчлэн судалгаанд оролцогчдын 16-25 орчим хувь нь шүүхэд итгэдэггүй, эсхүл эргэлзэж байгаа гэж хариулсанд анхаарал хандуулж, судлан тодруулж, эерэгээр өөрчлөх чиглэлд шаардлагатай арга хэмжээ авах хэрэгтэй.

**График 3.3. Шүүхийн шийдвэр Таны эсрэг гарвал Та ямар алхам хийх вэ?**



Шүүхийн шийдвэр өөрийнх нь эсрэг гарсан тохиолдолд шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн 44 хувь нь яагаад тийм шийдвэр гарсныг судална, 48.2 хувь нь шууд давж заалдана гэж хариулжээ. Шүүхийн шийдвэрийг давж заалдах Үндсэн хуульд заасан эрхээ эдлэх нь иргэдийн эрхийн асуудал тул зүй ёсны хэрэг юм. Шүүгчийг хардана гэсэн хариулт харьцангуй бага 2.9 хувь байгаа нь иргэд шүүгчийн хараат бус байдалд итгэж байгааг илтгэх үзүүлэлт гэж үзэхээр байна.


**График 3.4. Шүүхийн шийдвэр Таны эсрэг гарвал Та яах вэ? /Нийслэл, орон нутаг/**



Орон нутаг болон нийслэлд байрлах шүүхээр харьцуулж үзвэл хоорондоо хол зөрүүгүй, харилцан тэнцвэртэй байна.




**График 3.5. Шүүх хөрөнгө чинээ, эрх мэдэл, боловсрол зэргээр ялгаварладаггүй**



Шүүх хэргийн оролцогчдыг ялгаварладаг эсэх талаар иргэдээс асуухад шүүхээр үйлчлүүлж байсан болон үйлчлүүлж байгаагүй иргэдийн төсөөлөл хоорондоо эрс ялгаатай байгаа нь анхаарал татаж байна. Тухайлбал, шүүхээр үйлчлүүлж байгаагүй иргэдийн 46 хувь нь шүүх хөрөнгө чинээ, эрх мэдэл, боловсрол зэргээр хэргийн оролцогчдыг ялгаварладаггүй гэж, 20.9 хувь нь ялгаварладаг гэж үзсэн бол шүүхээр үйлчлүүлж байсан иргэдийн 63,4 хувь нь шүүх ялгаварладаггүй гэж үзжээ. Шүүхээр үйлчлүүлж байсан иргэд үйлчлүүлж байгаагүй иргэдтэй харьцуулахад шүүх иргэдийг ялгаварладаггүй гэсэн хариулт 20 орчим хувиар илүү байна. Энэ нь шүүхээр үйлчлүүлж байгаагүй иргэд шүүхийн талаарх бодит мэдээллээс хол байгааг харуулж байгаа бөгөөд төсөөлөл, таамаглалд тулгуурлан асуултад хариулсан байж болох талтай. Харин шүүхээр үйлчлүүлсэн иргэд шүүх шударга, тал татдаггүй гэдгийг илүү мэдэрдэг нь судалгааны дүнгээс харагдаж байна.

**График 3.6. Шүүх хөрөнгө чинээ, эрх мэдэл, боловсрол зэргээр ялгаварладаггүй /Нийслэл, орон нутаг/**




Орон нутагт болон нийслэлд байрлах шүүхээр харьцуулж үзвэл нийслэлийн шүүхүүдээр үйлчлүүлсэн иргэдийн хувьд илүү шүүмжлэлтэй хандаж байгаа байдал зөвхөн энэ асуултад бус ерөнхийдөө зонхилж буйг харж болно. Энэ нь нийслэлийн шүүхийн ачаалал, ажилтнуудын зан харьцаа, шүүхийн байрны зориулалт, дэд бүтэц, стандарт хангалтгүй байгаа зэрэгтэй холбоотой байж болохыг өмнө дурдсан. Нөгөө талаас төвлөрсөн хот, суурин газрын иргэд, үйлчлүүлэгчдийн эрэлт, хэрэгцээ, шаардлага, сэтгэл зүйн онцлог орон нутгийн иргэдийнхээс ялгаатай байж болох талтай.





#### 4. ШҮҮГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, ШҮҮГЧИЙН ТАЛААРХ ИРГЭДИЙН ТӨСӨӨЛӨЛ

**График 4.1. Шүүгчийн сонгон шалгаруулалтын талаар**




Шүүхийн шинэтгэлийн хүрээнд шүүгчид тавигдах болзол шаардлага, тэдгээрийг үнэлэх арга ажиллагааг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар шинэчлэн баталсан билээ. Шинэ сонгон шалгаруулалтын талаар иргэдийн 51 хувь нь буюу олонхи нь эерэг бодолтой байгаа нь тэдний зөв хүнийг олж байна, гайгүй байх гэж итгэж байна гэсэн хариултыг түлхүү сонгосноос харагдаж байна.

Харин иргэдийн 23 хувь нь шүүгчийн сонгон шалгаруулалтыг хүмүүс шүүмжилж байсныг сонссон, нэг л биш байна гэж хариулжээ. Үлдсэн 26 хувь нь энэ асуудлыг дүгнэж хэлээгүй байна.


Шүүхийн шинэтгэлээс өмнө шүүгчийн сонгон шалгаруулалт салбарын болон иргэдийн дунд хамгийн их шүүмжлүүлдэг сэдэв байсан. Шүүхэд цус ойртлоо, шүүх дотроосоо буюу явцуу хүрээнээс шүүгчид сонгогдож байна, сонгон шалгаруулалтад хүний нөлөө их, танил талтай нь шалгардаг гэсэн шүүмжлэлүүд байв. Харин шинэтгэлийн хүрээнд сонгон шалгаруулалтыг хүнээс хамгийн бага хамааралтай байхаар, технологийн дэвшил ашиглан хийж, бүх хуульчдыг тэгш өрсөлдөх бололцоог олгосны үр дүнд хамгийн их шүүмжлүүлж байсан энэ сэдвээр иргэдийн олонхи нь эерэг бодолтой болсон нь өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн ажлын үр дүн юм.

**График 4.2. Шүүгчийн сонгон шалгаруулалтын талаар /Нийслэл, орон нутаг/**



Орон нутагт байрлах шүүх болон нийслэлд байрлах шүүхээр харьцуулж үзвэл нийслэлд байрлах шүүхүүдэд үйлчлүүлсэн иргэд шүүгчийн сонгон шалгаруулалтын талаар илүү шүүмжлэлтэй хандаж байгаа нь харагдаж байна.


**График 4.3. Өөрийн нутаг дэвсгэрийн шүүгчийн талаарх Таны бодол**



Шүүхээр үйлчлүүлж байсан иргэдийн 69,9 хувь нь өөрийн оршин суудаг нутаг дэвсгэрийн шүүхийн шүүгчийн талаарх эерэг бодолтой байдаг байна. Тухайлбал, тэдний 36,5 хувь нь шүүгчдээ аргагүй л шүүгч хүн гэж боддог буюу хүндэтгэх сэтгэл төрдөг гэсэн бол 28.9 хувь нь шүүгчдээ боломжийн гэж үзжээ. Судалгаанд хамрагдсан иргэдийн 10 орчим хувь шүүгчид сэтгэл дундуур байдаг нь их жин эзлэхгүй байгаа нь шүүгчид итгэх итгэл дээшилсний илрэл юм.

Шүүхээр үйлчлүүлж байгаагүй иргэдийн хувьд мөн ихэнхи нь шүүгчдийн талаар эерэг бодолтой байдаг бөгөөд тэдний 1/3 нь шүүгчдийн талаар тухайлан үнэлэлт дүгнэлт өгч байгаагүй гэж хариулжээ.

**График 4.4. Өөрийн нутаг дэвсгэрийн шүүгчийн талаарх Таны бодол /Нийслэл, орон нутаг/**




Өөрийн нутаг дэвсгэрийн шүүгчийн талаар иргэд, олон нийт юу гэж боддог талаар орон нутаг болон нийслэлд байрлах шүүхээр харьцуулж харвал ерөнхий дүнгээс хол зөрөөгүй боловч нийслэлд байрлах шүүгчийн талаарх эерэг бодол орон нутгийн дүнгээс 10 орчим пунктээр бага байна.

## 5. ШҮҮХИЙН ШИНЭТГЭЛД ЦААШИД ТУЛГАРЧ БҮЙ СОРИЛТ

Санал асуулгын энэ хэсэгт шүүхийн шинэтгэлийн хүрээнд ямар ололтууд иргэдэд илүү хүрсэн бэ?, цаашид бид юун дээр анхаарах шаардлагатай вэ? гэсэн 2 багц асуултыг иргэдээс асуусан. Тус бүр 10 гаруй бодомж сонголттой багц асуултаас шүүхийн шинэтгэлийн хүрээнд иргэдэд харьцангуй бага мэдрэгдсэн гэж үзсэн чиглэлүүд нь цаашид анхаарах шаардлагатай гэж үзсэн шинэтгэлийн чиглэлүүдтэй давхцаж байна. /График 5.1. болон график 5.2./

**График 5.1. Шүүхийн шинэтгэлийн хүрээнд**



**График 5.2. Цаашид юунд анхаарах шаардлагатай вэ?**



Шүүхийн шинэтгэлийн хүрээнд шүүгч шударгаар хэрэг маргааныг шийдвэрлэдэг, шүүгч ёс зүйгээ сахидаг гэдэгтэй иргэд хамгийн ихээр санал нийлж байгаа нь шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлжээ. Энэ нь мөн График 4.2-т заасан үзүүлэлттэй дүйцэж байна.

Шүүхийн шинэтгэлийн хүрээнд цаашид анхаарах шаардлагатай чиглэлүүдийн хувьд иргэдийн 45 хувь нь шүүгчид сайн хүнийг томилох нь хамгийн чухал гэж үзжээ. Энэ нь шүүгч хариуцлагатай байдаг, шүүгчийн зан харьцаа, эелдэг, зөөлөн байдаг зэрэг үзүүлэлтүүд шинэтгэлийн хүрээнд өссөн гэж үзсэн иргэдийн хувь доогуур байгаатай уялдаж байна.

Иргэдийн 40 орчим хувь нь шүүгч, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд цаашид онцгой анхаарах шаардлагатай гэж үзжээ. Энэ судалгааны 1-р хэсэгт шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхэд ямар нэг хүндрэл гарсан уу гэж асуухад иргэдийн хамгийн их нь шүүгчдийн мэдлэг, чадварт эргэлзсэн гэж хариулсантай давхцаж байна. Шүүхийн шинэтгэлийн хүрээнд 2014 оноос хойш шүүгчдийн бүрэлдэхүүнийг олон шинэ шүүгчээр нэмэгдүүлсэн ч иргэд шүүгчдийн мэдлэг, ур чадвар хангалтгүй гэж үзэж байгаа хувь өндөр хэвээр байна. Эдгээр нь цаашид шүүхийн хүний нөөцийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх шаардлагатайг илэрхийлж байна.

Иргэд шүүгчид нөлөөлдөг танил талын нөлөөг хаах (35,8 хувь), шүүгч хараат бус ажиллах баталгааг бүрдүүлэхэд (39,1 хувь) анхаарах шаардлагатай гэж үзсэн анхаарал татаж байна.


Нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг болсоноор шүүгчид эрх мэдэл, хөрөнгө чинээтэй хүн дарамтлах маягаар шууд нөлөөлөх явдал эрс буурсан шинэтгэлийн нэг ололт юм. Гэвч энэ судалгааны үр дүнгээс харахад шүүгчид хувийн танил нь буюу дээд шатны албан тушаалтан гуйх буюу хариу нэхэх хэлбэрээр нөлөөлөх байдал байсаар байна гэж иргэд үзжээ. Иймд Шүүхийн ерөнхий зөвлөл цаашид шүүгчид нөлөөлдөг танил талын нөлөөг хаах чиглэлээр ажиллах шаардлагатайг судалгааны дүн харуулж байна.

Цаашид шүүхийн мэдээллийн ил тод байдлыг хангах ажлыг сайжруулах шаардлагатай гэж иргэдийн 35,6 хувь нь үзжээ. Шүүхийг нээлттэй болгох чиглэлээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн хийсэн ажлын үр дүнд сүүлийн 4 жилд эрс дэвшил гарсан. Энэ үйл явцыг улам гүнзгийрүүлж шүүх ба олон нийтийн харилцаа, хэвлэл мэдээлэл, сурталчилгааг эрчилмжүүлэх шаардлага байгааг тус судалгаа илтгэж байна. Иймд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхийг цахимжуулах, шүүхийг үйлчилгээний байгууллага болгох, хүнд суртлыг арилгах, үйл ажиллагааг хялбар, дөт, иргэдэд ойлгомжтой болгох чиглэлээр урт хугацааны шат дараалсан бодлого, арга хэмжээ авах шаардлагатай юм. Улсын Их Хурал, Засгийн газар ч шүүхийн үйлчилгээг орчин үежүүлэх чиглэлээр төсөв хөрөнгийг шийдвэрлэх, иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх ажилд анхаарах шаардлагатайг энэ судалгаанаас харж болно.

**График 5.3. Шүүхийн шинэтгэлийн хүрээнд /Нийслэл, орон нутаг/**



**График 5.2. Цаашид юунд анхаарах шаардлагатай вэ? /Нийслэл, орон нутаг/**



Шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдсэн ололтуудыг иргэдийн зүгээс сайшаасан хариултын эзлэх хувийн жин орон нутагт байрлах шүүхүүдийн хувьд ерөнхийдөө өндөр байгаа харагдана. Харин “шүүгч нөлөөнд орох эрсдэл багассан”, “шүүгч хүнийг ялгаварладаггүй” гэсэн асуултуудад нийслэл дэх шүүхүүдээр үйлчлүүлсэн иргэдийн хариулт өндөр байна. Энэ нь сүүлийн 3 жилд шүүгчийн орон тоог 50 хувиар нэмэгдүүлсэн, тэдний олонх нь нийслэлд хамаарч байгаа учир шүүгч, шүүхийн ачаалал буурч, үүнтэй холбоотой гарсан шүүхийн эерэг өөрчлөлтүүд нийслэлийн иргэдэд мэдрэгдэхүйц байсан гэж дүгнэж болно.

Харин цаашид юунд анхаарах талаар орон нутаг болон нийслэлд байрлах шүүхээр ялгаж үзвэл орон нутагт хамгийн их дэмжлэг авч байгаа, шинэтгэлийг улам гүнзгийрүүлэх шаардлагатай гэж үзсэн чиглэл бол “эвлэрүүлэн зуучлах ажиллагаа” байна. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны сүүлийн 3 жилийн тайлан мэдээнээс үзэхэд улсын хэмжээнд эвлэрүүлэн зуучлал амжилттай

болсон хувь 72 орчим хувь байгаагаас дийлэнх аймгуудад энэ үзүүлэлт 80-98 хувьтай байна. Шүүхийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны давуу тал, ач холбогдол орон нутагт илүү сайн мэдрэгдэж байгаа нь эвлэрүүлэн зуучлалын тайлан, тоон мэдээ болон энэхүү судалгааны үр дүнгээс мөн харагдаж байна. Энэ нь нөгөө талаас нийслэл дэх шүүх иргэдийг эвийн журмаар хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх боломжийг бүрдүүлэх, эвлэрүүлэн зуучлалыг шүүхэд ашиглах боломж, түүний давуу талыг таниулсан мэдээлэл, сурталчилгааг сайн хэрэгжүүлэх хэрэгтэй.

Нийслэлд “шүүгч хараат бус ажиллах баталгааг бүрдүүлэх”, “шүүгчийг хэрэг, маргааны төрлөөр дагнан мэргэшүүлэх”, “хууль тогтоомжийг шинэтгэх” зэрэг асуудлуудыг илүү чухалчилж цаашид шинэтгэлийг гүнзгийрүүлэх хэрэгтэй гэж үзсэн байна.

## **ДҮГНЭЛТ**

